БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан  сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/43/НА-СТА-ТШ3**

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com

Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ /эх хувь ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 11

3. Аудитын тайлан ..... 11

3.1 Ерөнхий зүйл ..... 11

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12

3.4 Материаллаг байдал ..... 13

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 15

3.8 Аудитын гол асуудал ..... 15

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16

4. Аудитын илрүүлэлт ..... 16

**4.1 Төлбөрийн акт** ..... 16

**4.2 Зөвлөмж** ..... **Error! Bookmark not defined.**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын гэрчилгээ /эх хувь

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/82

танай ____________ -ны № ____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Д.САРМАНДАХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020422

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43.009.345.61** | **401.126.892.99** |
| **33** | **АВЛАГА** | 266.930.33 | 327.086.000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 101.930.33 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 327.086.000.00 |
| **335** | **Бусад авлага** | 165.000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 165.000.00 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 200.000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 00.00 | 200.000.00 |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 00.00 | 200.000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 42.742.415.28 | 73.840.892.99 |
| **351** | **Түүхий эд материал** | 5.921.142.00 | 38.408.595.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 800.000.00 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 5.121.142.00 | 38.408.595.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 36.821.273.28 | 35.432.297.99 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1.383.100.00 | 831.000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 696.000.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 00.00 | 629.650.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2.160.000.00 | 2.600.000.00 |
| 35460 | Хүнсний материал | 737.910.00 | 4.705.810.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 31.844.263.28 | 26.665.837.99 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1.709.967.410.39** | **1.718.500.006.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1.709.967.410.39 | 1.718.500.006.37 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1.684.304.410.39 | 1.692.905.756.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1.739.069.245.55 | 1.739.069.245.55 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -122.638.259.55 | -181.322.440.59 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 38.150.000.00 | 38.150.000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -20.033.414.98 | -26.187.500.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 178.308.353.05 | 269.810.198.61 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -148.141.400.45 | -167.287.788.46 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 63.922.098.05 | 69.182.393.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44.490.211.28 | -48.966.352.20 |
| 39217 | Ном | 158.000.00 | 458.000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 25.663.000.00 | 25.594.249.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26.113.000.00 | 26.113.000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -450.000.00 | -518.750.04 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1.752.976.756.00** | **2.119.626.899.36** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **500.00** | **8.493.545.94** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 500.00 | 8.493.545.94 |
| **413** | **Өглөг** | 500.00 | 8.493.545.94 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 1.091.976.34 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 500.00 | 7.401.569.60 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1.752.976.256.00** | **2.111.133.353.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1.752.976.256.00 | 2.111.133.353.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 403.539.875.00 | 403.539.875.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 403.539.875.00 | 403.539.875.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1.322.663.553.74 | 1.680.820.651.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1.322.663.553.74 | 1.322.663.553.74 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 358.157.097.42 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 26.772.827.26 | 26.772.827.26 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1.752.976.756.00** | **2.119.626.899.36** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **548.987.292.91** | **1.278.760.218.22** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **17.818.328.91** | **95.420.796.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 17.818.328.91 | 95.420.796.22 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 17.818.328.91 | 79.700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 139.100.00 | 79.700.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 17.679.228.91 | 00.00 |
| **120017** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үх | | **71.826.451.01** |
| **120018** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бм | | **23.514.645.21** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **109.613.164.00** | **702.762.222.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 421.555.800.00 | 480.577.200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12.699.804.00 | 611.871.128.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12.699.804.00 | 53.676.128.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 327.086.000.00 |
| **131107** | **нэмэлт** | | 231.109.000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 70.081.500.00 | 74.388.854.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 70.081.500.00 | 74.388.854.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 26.831.860.00 | 16.502.240.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 26.831.860.00 | 16.502.240.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **601.384.374.68** | **920.603.120.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **601.384.374.68** | **920.603.120.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 588.575.170.08 | 847.623.299.88 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 316.914.026.00 | 358.004.749.94 |
| 210101 | Үндсэн цалин | 316.294.617.00 | 358.004.749.94 |
| 210102 | Нэмэгдэл | 619.409.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39.696.822.12 | 48.921.233.81 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27.265.250.12 | 34.472.482.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3.209.145.00 | 3.828.436.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2.550.516.00 | 3.054.107.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 606.389.00 | 714.566.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6.065.522.00 | 6.851.642.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 69.360.497.72 | 73.278.854.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2.585.167.72 | 3.736.066.00 |
| 210302 | Түлш, халаалт | 66.041.930.00 | 69.142.788.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 733.400.00 | 400.000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19.391.588.00 | 33.832.129.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1.112.700.00 | 3.245.000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15.805.988.00 | 28.406.129.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1.980.000.00 | 2.001.000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 266.900.00 | 180.000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 226.000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 37.376.730.44 | 148.288.892.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27.910.200.44 | 118.544.702.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 6.752.530.00 | 29.744.190.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2.714.000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 82.000.00 | 00.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 60.000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 22.000.00 | 00.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1.342.000.00 | 758.000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1.342.000.00 | 758.000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 429.700.00 | 68.267.249.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29.700.00 | 67.817.249.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400.000.00 | 450.000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 103.981.805.80 | 116.272.190.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15.482.955.07 | 27.742.645.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 88.498.850.73 | 88.529.545.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12.809.204.60 | 72.979.820.92 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12.699.804.00 | 53.276.127.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 31.000.000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12.699.804.00 | 22.276.127.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 109.400.00 | 00.00 |
| 213404 | Хөрөнгийн | 109.400.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.60 | 19.703.693.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.60 | 19.696.997.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-52.397.081.77** | **358.157.097.42** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-52.397.081.77** | **358.157.097.42** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **531,308,064.00** | **856,333,122.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **139,100.00** | **79,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 139,100.00 | 79,700.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 139,100.00 | 79,700.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 139,100.00 | 79,700.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **531,168,964.00** | **856,253,422.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 421,555,800.00 | 480,577,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,699,804.00 | 284,785,128.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,699,804.00 | 53,676,128.00 |
| 131107 | нэмэлт | | 231.109.000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 70,081,500.00 | 74,388,854.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 70,081,500.00 | 74,388,854.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 26,831,860.00 | 16,502,240.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 26,831,860.00 | 16,502,240.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **531,308,064.00** | **853,343,122.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **531,308,064.00** | **853,343,122.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **518,498,857.12** | **780,363,301.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 320,383,361.00 | 360,429,355.94 |
| 210101 | Үндсэн цалин | 223,779,256.35 | 232,510,535.40 |
| 210102 | Нэмэгдэл | 73,622,436.93 | 101,899,085.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 5,747,649.80 |
| 210104 | Урамшуулал | 22,981,667.72 | 20,272,085.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,329,417.45 | 44,763,802.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,897,862.45 | 30,007,754.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,209,146.00 | 3,682,381.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,550,516.00 | 2,930,353.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 606,389.00 | 737,755.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,065,504.00 | 7,405,559.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 69,360,497.72 | 73,888,854.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,585,167.72 | 4,346,066.00 |
| 210302 | Түлш, халаалт | 66,041,930.00 | 69,142,788.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 733,400.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,787,688.00 | 29,966,299.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,193,500.00 | 1,184,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,405,988.00 | 24,208,399.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,016,000.00 | 2,001,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,147,200.00 | 1,918,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,025,000.00 | 654,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 34,966,792.95 | 29,873,159.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 25,949,792.95 | 24,048,459.20 |
| 210502 | Хоол, хүнс | 6,300,000.00 | 5,824,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,717,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,039,400.00 | 1,650,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,478,400.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,561,000.00 | 1,650,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,342,000.00 | 658,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,342,000.00 | 658,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 429,700.00 | 232,032,005.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,700.00 | 231,582,005.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,860,000.00 | 7,101,825.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,860,000.00 | 7,101,825.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **12,809,206.88** | **72,979,820.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,699,804.00 | 53,276,127.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 31,000,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,699,804.00 | 22,276,127.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 109,402.28 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 02.28 | 00.00 |
| 213404 | Хөрөнгийн | 109,400.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.60 | 19,703,693.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.60 | 19,696,997.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **2,990,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **2,990,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **2,990,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 2,990,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 2,990,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-2,990,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 403.539.875.00 | 26.772.827.26 | 1.432.238.901.09 | 00.00 | 1.862.551.603.35 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **403.539.875.00** | **26.772.827.26** | **1.432.238.901.09** | **00.00** | 1.862.551.603.35 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -32.413.751.08 | 00.00 | -32.413.751.08 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **403.539.875.00** | **26.772.827.26** | **1.322.663.553.74** | **00.00** | 1.752.976.256.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | **2021оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **403.539.875.00** | **26.772.827.26** | **1.322.663.553.74** | **00.00** | 1.752.976.256.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **403.539.875.00** | **26.772.827.26** | **1.322.663.553.74** | **00.00** | 1.752.976.256.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 358.157.097.42 | 00.00 | 358.157.097.42 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **403.539.875.00** | **26.772.827.26** | **1.680.820.651.16** | **00.00** | 2.111.133.353.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 598.446.400.00 | 551.771.296.08 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 598.446.400.00 | 551.771.296.08 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 598.446.400.00 | 551.771.296.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 387.313.200.00 | 360.429.355.94 |
| 210101 | Үндсэн цалин | 241.125.300.00 | 232.510.535.40 |
| 210102 | Нэмэгдэл | 103.089.100.00 | 101.899.085.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6.930.000.00 | 5.747.649.80 |
| 210104 | Урамшуулал | 36.168.800.00 | 20.272.085.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52.287.300.00 | 44.763.802.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36.794.700.00 | 30.007.754.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3.873.100.00 | 3.682.381.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3.098.600.00 | 2.930.353.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 774.600.00 | 737.755.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7.746.300.00 | 7.405.559.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 80.198.400.00 | 73.888.854.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5.049.400.00 | 4.346.066.00 |
| 210302 | Түлш, халаалт | 74.749.000.00 | 69.142.788.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400.000.00 | 400.000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30.674.400.00 | 30.250.499.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 1.200.000.00 | 1.184.300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24.208.400.00 | 24.208.399.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2.016.000.00 | 2.001.000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300.000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2.000.000.00 | 1.918.100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 950.000.00 | 938.700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 32.914.000.00 | 29.873.159.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24.104.000.00 | 24.048.459.20 |
| 210502 | Хоол, хүнс | 6.300.000.00 | 5.824.700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2.510.000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2.000.000.00 | 2.000.000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2.000.000.00 | 2.000.000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1.357.100.00 | 658.000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1.357.100.00 | 658.000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 450.000.00 | 450.000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450.000.00 | 450.000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11.252.000.00 | 9.457.625.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11.252.000.00 | 9.457.625.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 598.446.400.00 | 551.771.296.08 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 480.577.200.00 | 460.880.202.08 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 480.577.200.00 | 460.880.202.08 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 80.698.400.00 | 74.388.854.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 80.698.400.00 | 74.388.854.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 37.170.800.00 | 16.502.240.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 37.170.800.00 | 16.502.240.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 28.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 18.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 09.00 |

## 2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12.809.204.00** | **284.785.128.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12.809.204.00** | **284.785.128.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 231.502.305.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 109.400.00 | 231.502.305.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109.400.00 | 231.502.305.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | 31.000.000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12.699.804.00 | 22.276.127.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **6.696.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 6.696.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 12.809.204.00 | 284.785.128.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12.809.204.00 | 284.785.128.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12.699.804.00 | 53.676.128.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 109.400.00 | 231.109.000.00 |
| 131107 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 109.400.00 | 231.109.000.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр ”Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Сармандах нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бууцагаан сумын ЭМТ нь Хүн амын нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 608,884.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,133.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,849.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 10,356.7 мянган төгрөг буюу 3,507.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 341280.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бууцагаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 2,119,626.9 мянган төгрөг болж өмнөх оноос 366,650.1 мянган төгрөгөөр буюу 17,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө , өглөгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 43.009.3 | 401.126.9 | 358.117.5 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 266.9 | 327.086.0 | 326.819.1 |
| Урьдчилгаа | - | 200.0 | 200.0 |
| Бараа материал | 42.742.4 | 73.840.9 | 31.098.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1.709.967.4 | 1.718.500.0 | 8.532.6 |
| Үндсэн хөрөнгө | 2.045.720.7 | 2.142.782.8 | 97.062.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (335.753.3) | (424.282.8) | (88.529.5) |
| **Нийт хөрөнгө** | 1.752.976.8 | 2.119.626.9 | 366.650.1 |
| Өр төлбөр | 0.5 | 8.493.5 | 8.493.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1.752.976.3 | 2.111.133.4 | 358.157.1 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1.752.976.8 | 2.119.626.9 | 366.650.1 |

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 73,840.9 мянган төгрөг болж 31,098.5 мянган төгрөгөөр өссөн нь, эм боох материалын дансны үлдэгдэл 33,287.4 мянган төгрөг болж өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй

холбоотой байна. Тайлант онд аймгийн онцгой комиссоос 2,700.0 мянган төгрөгийн ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэл өгсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 326,819.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМД-ын сангаас Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт бүрэн орж ирээгүйтэй холбоотой ба үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Өглөг дансны үлдэгдэл 8,493.5 мянган төгрөг болж нэмэгдсэн нь ЭМД-ын санхүүжилт бүрэн орж ирээгүйгээс үүссэн ба энэ нь ажиллагсадтай холбогдсон 1,091.9 мянга, эмийн 7,401.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна. Үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,142,782.8 мянган төгрөг болж 97,062.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 21,255.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,680.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 67,646.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,580.2 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг Аймгийн Эрүүл мэндийн газраас шилжүүлэн авч, 4,849.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж 2 иргэнээс хандиваар авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,111,133.4 мянган төгрөг болж 358,157.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал,тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 598,446.4 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 598,446.4 мянган төгрөгийн төсөв батласнаас улсын төсвөөс 480,577.2 мянга, орон нутгийн төсвөөс 80,698.4 мянга, ЭМДС-гаас 37,170.8 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 480,577.2 мянга, орон нутгийн төсвөөс 74,388.8 мянга, ЭМД-аас 16,502.2 мянга, нийт 571,468.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 551,771.2 мянган төгрөгийг зарцуулсан байна, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6,309.5 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 20,668.5 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 551,771.2 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь ЭМД сангаас санхүүжих санхүүжилт 3,439.4 мянган төгрөг дутуу байгаагаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 155,254.9 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 101,795,0 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ,улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Ковид-19 цар тахлын хүрээнд Сумын онцгой комиссын шийдвэрийн дагуу тусгаарлан ажиглах 48 ортой байрыг сургууль, ЗДТГ-ын буудал зэрэгт бэлтгэсэн. Өөрийн халдвартын эмнэлгийг тусгаарлан эмчлэх эмнэлэг буюу улаан бүс болгож 10 ортойгоор дэлгэж, хуваарийн дагуу эмч сувилагч үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэй тусгаарлан эмчлэх эмнэлэгтээ 7-14 хоногийн хугацаатай ажиллаж тусламж үйлчилгээгээ үзүүлсэн. Нийт 347 өвчтөнийг хэвтэн эмчлүүлсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баян ташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор Т.Хоролсүрэн санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 32 ажлыг тусган хэрэгжилтийг ханган ажилласан хэрэгжилт 90%-тай гэж тайлагнасан .

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 627788,5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 192,123,9 мянган төгрөгөөр буюу 44,1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 20,365,1 мянган , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 136,193.2 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

**3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр шатах тослох материал, хүнсний материал худалдан авах ажиллагааг Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын А/29, А/31 дугаар бүхий захирамжуудаар НИК ХХК, "Бүүвэй ус" ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Зөрчилгүй санал дүгнэлт авсан. ЭМТ-н дарга О. Гэрэлчимэгт сахилгын шийтгэл авсан байхад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон. Мөн НБББББ байхгүй гэсэн зөрчил илэрсэн. 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдөр төлбөрийн актыг барагдуулж 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 37 тоот албан чигээр хариуг хүргүүлсэн. Мөн 2021оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 64 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант хугацаанд 326,819.1 мянган төгрөгийн авлага, 8,493.5 мянган төгрөгийн өглөг үүссэн ба түүний барагдуулалт зарцуулалтад анхаарал хандуулах шаардлагатай байна. Цаашид хүн амын өвчлөлтэй холбоотой санхүүгийн тайланд үүсэж байгаа өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд байгууллагын болон орон нутгийн удирдлага хамтран анхаарч ажиллах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,783.6 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрч, 5,783.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоов.

**4.1 Төлбөрийн акт**

**4.1.1**. ЭМТ-ийн төсөвт хоолны мөнгийг ажилласан өдөрт 1 хүнд 1000 төгрөгөөр тогтоон сар бүр олгосон байхад 2021.12.14-ны Б/53 дугаар тушаалаар ажилчдад хоолны мөнгөнд 4,906.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон/ 22 хүнд 223.0 мянган төгрөг/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар

төлөвлөж, зарцуулах;, санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Холбогдох ажилтнуудаар 4,906.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов

**4.1.2**. Сумын Засаг даргын 2021.12.15-ны Б/56 тоот захирамжаар ЭМТ-ийн даргад эмчлэгч их эмчийн ажлыг 10.11.12 дугаар сард хавсруулан гүйцэтгүүлж, нэмэгдлийг 40.0%-иар тооцон олгох, 2021.12.15-ны Б/55 тоот захирамжаар ЭМТ-ийн даргад ур чадварын нэмэгдлийг 9,10,11 дүгээр сарынхыг нөхөж олгохоор шийдвэрлэсний дагуу 877,6 мянган төгрөгийг олгосон байна

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, **сар бүр олгоно**, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.Энэ хуулийн 43.3.1-д зааснаас бусад тохиолдолд төрийн жинхэнэ албан **хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан 14 хоногийн дотор гаргана** гэснийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:**Холбогдох ажилтнаар 877,6 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов**.**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв | 2 | 5,783.6 | 0 | 0,00 | 2 | 5,783.6 | 0 | 0,0 | 0 | 0,00 |

______oOo______